

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор:

Ч.Ариунаа

Аудитын менежер:

Ч.Хэрлэнчимэг

Ахлах аудитор:

Л.Аваадорж

Аудитор:

Б.Тунгалагтуяа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	3-4
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
ХОЁР. САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ	6
ГУРАВ. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	6
ДӨРӨВ. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	6-7
ТАВ. МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ	7
ЗУРГАА. АВЛАГЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ	7-9
ДОЛОО. БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ.....	9
НАЙМ. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ,ТАЙЛАГНАЛ	10
ЕС. ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ ТАЙЛАГНАЛ	
9.1. Богино хугацаат өр төлбөр	11-12
9.2. Урт хугацаат өр төлбөр	12
АРАВ. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ	
10.1. Төсвийн төлөвлөгөө	12-13
10.2. Төсвийн гүйцэтгэл	13-15
АРВАН НЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	
11.1. Татварын орлого	15-16
11.2. Татварын бус орлого	17
11.3. Хөрөнгийн орлого	17
АРВАН ХОЁР. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА	
12.1. Урсгал зардал	17-18
12.2. Хөрөнгийн зардал	18-19
АРВАН ГУРАВ. ТӨСӨЛ САНГУУДЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ.....	19
АРВАН ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИУД.....	20
АРВАН ТАВ. ТӨСВИЙН ШУУД БОЛОН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН.....	20-21
АРВАН ЗУРГАА. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	21
АРВАН ДОЛОО. ТАЙЛАНТ ОНЫ АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	22
АРВАН НАЙМ. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГУУД	23-41
Хавсралт 1. ТШЗ, ТТЗ-ийн аудитаар зөрчилтэй дүгнэлт авсан байгууллагууд	
Хавсралт 2. ТШЗ, ТТЗ-ийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	

2017 оны 4 дүгээр сарын 20

Уг тайланг ҮАГ-ын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-3020 дугаарын утас, 70522734 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Дорноговь аймаг Сайншанд сум 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ОНӨҮГ	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХХК	ОН-ийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	ОН-ийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас: (705) 2-27-34

2017.04.20 № 1-6/392
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Т.ЭНХТҮВШИН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3, 18.2-т заасан бүрэн эрхийн дагуу Дорноговь аймаг дахь Төрийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн төсвийн жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллагын аудиторууд нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар орон нутгийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, гол хууль тогтоомжуудын хэрэгжилтийг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

0824700

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийх үндэслэл

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан бүрэн эрхийн дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар нутгийн өөрөө удирдах болон хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудал болно.

Аудитын арга зүй

Санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, шинжилгээний горим, хяналтын болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв. Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Материаллаг байдал

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг байдлыг нийт хөрөнгийн дүнгээс 0.5 хувиар тооцон 722.4 сая төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс төсөвт байгууллагуудын өдөр тутмын гүйлгээнд Freebalans програмаар хяналт тавьж, санхүүгийн тайланг тойрох хуудсаар хүлээн авч Сангийн яамны нэгдсэн системд оруулан хяналт тавин ажиллаж байна.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2012–2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас дотоод хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар орон нутгийн төсвийн орлого, зарлага, орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангууд, орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үр дүн зэрэг асуудлуудыг хамруулсан байна. Шалгалтын дүн, тайлан эцсийн байдлаар баталгаажиж ирээгүй байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс 2017 оны 02 дугаар сараас эхлэн төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн томилон ажиллуулж эхэлсэн бөгөөд 2017 онд 14 сумыг хамруулсан дотоод хяналт, шалгалт хийх удирдамжид саналаа өгч тусгуулан ажиллаж байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөлтийн үе шатанд дотоод хяналтын эрсдэл “хэвийн” гэж үнэлсэн.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу улс, орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй байлгах зорилгоор төсвийн гүйцэтгэлийг мэдээлэх түүнд олон нийт болон төрийн аудитын байгууллага хяналт тавьж ажиллахаар заасан.

Аудитын газраас 2016 онд 2 удаа шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн. Аудитаар шилэн дансны цахим хуудсанд аудитын дүгнэлт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр зэрэг 2.5 тэрбум төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэн. Иймд мэдээллийг нөхөн байршуулахаар холбогдох албан тушаалтнуудад хугацаатай 68 албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулсан байна.

Дөрөв. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл сангуудын нийт 237 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Одгийн үйлдвэрийн орлого 19,107.6 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 17,090.4 мянган төгрөгийн орлого өндөрчлөхөөс. Орлогын төлөвлөгөөний биелэлт 89.4 хувьтай буюу 2,017.2 сая төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна.

Орон нутгийн төсөвт нийт 19 нэр төрлийн татварын орлого төвлөрүүлэхээс 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелж, 10 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Төсвийн нийт зардал 54,172.9 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 50,676.0 мянган төгрөгөөс 3,496.9 мянган төгрөгөөс хэмнэгдсэн байна.

Нийт төсвийн гүйцэтгэлийн зарлагын 47.0 хувийг орон нутгийн төсөвт байгууллага, 53.0 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага эзэлж байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв 27,060.6 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 26,973.0 сая төгрөг зарцуулж 87.6 сая төгрөгөөр төсвийн зардал хэмнэгджээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 5,773.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Сумдын орон нутгийн хөгжлийн санд 2,835.8 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн санд 2,744.0 сая төгрөг хуваарилж, нийт 5579.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тав. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 28.5 хувиар буюу 441.9 сая төгрөгөөр нэмэгдэж 1,988.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгө нэмэгдэхэд төрийн сангийн дансны үлдэгдэл 280.3 сая төгрөгөөр, арилжааны банкин дахь дансны үлдэгдэл 161.6 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Төрийн сангийн нэгдсэн дансанд 1,533.0 сая төгрөгийн, арилжааны банкинд 455.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Арилжааны банкинд төсөвт байгууллагын 38, орон нутгийн орлогын 15, халамжийн сангийн 5, орон нутгийн өмчит компанийн 39 данс байршиж байна.

Зургаа. Авлагын бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн нийт авлагын үлдэгдэл 5.6 тэрбум төгрөгийн 66 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 10 хувийг байгууллагаас авах авлага, 22 хувийг ОНӨҮГ-ын авлага, 2 хувийг бусад авлага тус тус эзэлж байна.

Нийт авлагын дүн өмнөх оноос 11.4 хувиар буюу 581.8 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын өөрчлөлт (сая төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн+, хасагдсан-
СХСангийн зээлийн авлага	3,314.4	3,747.2	432.8
Байгууллагаас авах авлага	172.9	565.6	392.7
Хувь хүнээс авах авлага	11.5	36.8	25.3
Ажилчидтай холбоотой авлага	6.3	29.6	23.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	3.5	5.3	1.8
ОНӨҮГ-ын авлага	1,557.2	1,263.1	-294.1
Нийт дүн	5,065.8	5,647.6	581.8

Авлага өсөхөд сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 432.8 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 392.7 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага өссөн нь сумдын өмнөх онуудын зээлийн авлагыг эргэн нягталж санхүүгийн тайланд тусгагдаагүй байсан авлагыг нэмж

тусгаснаас шалтгаалжээ. Тухайлбал: Замын-Үүд сум 437.7 сая төгрөг, Сайхандулаан сум 111.1 сая төгрөг, Дэлгэрэх сум 70.4 сая төгрөгөөр зээлийг нэмж бүртгэсэн бол Айраг сум 123.6 сая төгрөгөөр зээлийн авлагыг бууруулсан байна. Айраг сум зээлийн авлагыг анхан шатны баримтгүйгээр хасч тайлагнасан зөрчилд холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн.

Байгууллагаас авах авлага тайлант онд 392.7 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнийг байгууллагаар ангилж харуулбал:

№	Байгууллагын нэр	Авлагын эцсийн үлдэгдэл	Үүнээс 2016 онд нэмэгдсэн дүн /сая төг/
1	Аймгийн ОНХСан	246.3	201.9
2	Аймгийн ГХБХБГ	22.1	22.1
3	Сайншанд сум	166.9	77.5
4	Даланжаргалан сум	53.6	53.3
5	Иххэт сум	43.1	18.7
6	Эрдэнэ сум	14.0	12.4
7	Бусад сум	19.6	6.8
	Нийт дүн	565.6	392.7

Байгууллагаас авах авлага нэмэгдэхэд голлон нөлөөлсөн зүйл:

- Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хийгдсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийг төсвийн тодотголоор 2017 онд шилжүүлснээр 201.9 сая төгрөгийн авлага үүссэн.
- Аймгийн ГХБХБГазар нь орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын ажлуудын техник хяналтын зардлын дутуу 22.1 сая төгрөгийг авлагаар тусгасан.
- Даланжаргалан сумын ЭМТ, ЕБС, Цэцэрлэг нийт 53.6 сая төгрөгийг аймгийн Татварын хэлтэст илүү шилжүүлж авлага үүсгэсэн.
- Иххэт сумын ЕБС 20.2 сая төгрөгийг Татварын хэлтэст, 21.4 сая төгрөгийг Чандмань-Илч ОНӨХХК-д илүү шилжүүлсэн.
- Сайншанд сумын төсөвт байгууллагууд 2016 оны зардлын хэмнэлтээс 40.2 сая төгрөгийг аймгийн Татварын хэлтэст, түлш халаалтын зардлаас 46.9 сая төгрөгийг Чандмань-Илч ОНӨХХК-д илүү шилжүүлж авлагыг нэмэгдүүлсэн

Зарим сумын төсөвт байгууллагууд /ихэвчлэн тусгай шилжүүлгийн байгууллагууд/ аймгийн Татварын хэлтэст 159.9 сая төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн. Үүнд:

- Айраг сумын ЕБС, цэцэрлэг 6.7 сая төгрөг;
- Дэлгэрэх сумын ЕБС, ЭМТ, цэцэрлэг 24.1 сая төгрөг;
- Эрдэнэ сумын ЗДТГ, ЕБС, цэцэрлэг 9.9 сая төгрөг;
- Замын-Үүд сумын төсөвт байгууллагууд 5.2 сая төгрөг;
- Даланжаргалан, Иххэт, Сайншанд сумын төсөвт байгууллагууд нийт 114.0 сая төгрөгийг шилжүүлж санхүүгийн тайлан дахь авлагыг их хэмжээгээр өсгөсөн

Дээрх байгууллагууд зориудаар их хэмжээний авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*” гэсэн заалтыг зөрчсөн.

Авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулах ажил хангалтгүй хийгдэж байна. Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс авлагын эзэн холбогдогч тодорхойгүй болох, эргэн төлөгдөхгүй байх зэрэг эрсдэл үүсч байна.

- Аймгийн төсвөөс Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2007 онд арилжааны банкинд байршуулсан 60 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- 2000 онд улсын төсвөөс авсан өвс тэжээлийн өр 23.2 сая төгрөгийг аймгийн төсвөөс Сангийн яаманд төлж барагдуулсан боловч сумдаас аймгийн төсөвт буцаан авах авлага тухайн үед тооцоо нийлж баталгаажуулаагүйн улмаас одоо хэрхэн барагдуулах нь тодорхойгүй байна.
- Хандивын сан нэртэй дансанд 21 сая төгрөгийн эзэн холбогдогч тодорхойгүй авлага 2011 онд бүртгэгдсэн.
- Чандмань-Илч ОНӨХХК байгууллагаас авах авлага 436.9 сая төгрөг, Эм эргэлтийн сан ОНӨҮГ 13.4 сая төгрөгийн авлагыг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Даланжаргалан, Өргөн сумдад олон жил болсон, эзэн холбогдогч тодорхойгүй 3.2 сая төгрөгийн авлага, Хатанбулаг суманд төлөгдөхгүй олон жил болсон 4.6 сая төгрөгийн авлага байна.

Дээрх алдаа зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах*” гэсэн заалтыг зөрчиж байна.

Долоо. Бараа материалын бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эцсийн үлдэгдэл 5,400.5 сая төгрөгөөр тайлагнагдаж, өмнөх оноос 1,159.6 сая төгрөгөөр өссөн байна.

(сая төгрөгөөр)			
Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Түүхий эд материал	458.4	558.3	99.9
Хангамжийн материал	3779.8	4834.3	1054.5
Нөөцийн бараа	2.7	7.9	5.2
Нийт дүн	4240.9	5400.5	1159.6

Хангамжийн материал 1,054.5 сая төгрөгөөр, түүхий эд материал 99.9 сая төгрөгөөр, нөөцийн бараа 5.2 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсөвт байгууллагууд бараа материалын тооллогыг чанаргүй явуулдаг, тооллогын бүртгэл хөтөлж тооцоо бодсон актаар баталгаажуулдаггүй, бараа материалын тайлан гаргадаггүй зэрэг зөрчил илэрсэн.

Найм. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Үндсэн хөрөнгө 2016 онд 5.2 хувь буюу 9.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 178.8 тэрбум төгрөг болж нэмэгдсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)			
Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү дүн
Барилга байгууламж	102,226.9	107,341.8	5,114.9
Тээврийн хэрэгсэл	6,666.4	6,967.9	301.5
Машин тоног төхөөрөмж	11,085.0	12,506.8	1,421.8
Тавилга эд хогшил	4,502.7	4,994.4	491.7
Дуусаагүй барилга	0.0	2.0	2.0
Түүх соёлын дурсгалт зүйлс	681.9	695.2	13.3
Ном	445.7	509.9	64.2
Зам, гүүрийн байгууламж	31,199.8	31,364.8	165.0
Бусад үндсэн хөрөнгө	12,509.6	14,259.9	1,750.3
Биет бус хөрөнгө	155.1	169.5	14.4
Дүн	169,473.1	178,812.2	9,339.1

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой 4,269.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Чандмань Илч ОНӨХХК, Сайншанд сумын ИТХ, Зүүнбаян баг, Замын-Үүд сумын ЗДТГазар нийт 6.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.
- Зүүнбаян багийн Соёлын төв балансаас балансад шилжүүлсэн 17.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж аваагүй.
- Хатанбулаг сумын ЗДТГазар 21.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсан байхад данснаас хасаагүй.
- Айраг, Сайхандулаан, Улаанбадрах сумдын ЕБСургууль 15.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн.
- Аймгийн ИТХурал 1.1 сая, Замын-Үүд сумын ИТХ, ЗДТГазар 4.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан.

Ес. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал**9.1. Богино хугацаат өр төлбөр:**

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөр 238.5 сая төгрөгөөр өсч оны эцэст 3,073.3 сая төгрөгт хүрсэн байна. Богино хугацаат өр, төлбөрийн өөрчлөлтийг харуулбал:

Богино хугацаат өр төлбөр (сая төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн+, хасагдсан-
Ажилчидтай холбоотой өглөг	59.3	63.4	4.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	62.5	11.4	-51.1
Байгууллагад төлөх өглөг	2,472.5	2,697.3	224.8
Хувь хүмүүст төлөх өглөг	211.5	248.3	36.8
Татвар, НДШ-ийн өглөг	4.5	9.9	5.4
Бусад өглөг	24.5	43.0	18.5
Нийт дүн	2,834.8	3,073.3	238.5

Байгууллагад төлөх өглөг 224.8 сая төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөг 36.8 сая төгрөгөөр өсч, бараа үйлчилгээний зардлын өглөг 51.1 сая төгрөгөөр буурсан байна.

Байгууллагад төлөх өглөг өсөхөд нөлөөлсөн зүйл:

- Аймгийн ОНХС-гийн өглөг 201.9 сая төгрөгөөр, халамжийн сангийн өглөг 79.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн.
- Хувь хүмүүст төлөх өглөг өссөн нь халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмжийн өглөг нэмэгдсэнээс шалтгаалсан.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын дутуу санхүүжилт 930.2 сая төгрөг, халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмжийн дутуу 318.6 сая төгрөгийн өглөг нийт 1,248.8 сая төгрөгийн орон нутгийн төсвийн дотоод өглөг шинээр үүсээд байна.

- Аймгийн ИТХ-ын тодотголоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын санхүүжилтээс 930.2 сая төгрөгийг дараа онд шилжүүлснээр дээрх өр үүссэн.
- Халамжийн сан 2016 оны эхэнд 164.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн өртэй байсныг төсвийн тодотголоор нэмж батлан өрийг барагдуулсан байна. Гэтэл халамжийн сангаас санхүүгийн тайланд тусгагдаагүй өмнөх оны өр 343.7 сая төгрөгийг олгосноор, 2016 оны 318.6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж иргэдэд олгогдолгүй өр үүсээд байна.
- Халамжийн сангийн мэргэжилтнүүдийн хариуцлагагүй байдлаас шалтгаалан өмнөх оны өрийг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй, санхүүгийн тайланд тусгагдаагүй өглөгийг 2016 оны төсвөөс олгосон зэргээс шалтгаалан дээрх өр үүссэн байна.
- Халамжийн сангийн нийт санхүүжилт өмнөх оноос 602.0 сая төгрөгөөр өссөн бөгөөд үүн дээр 2016 оны олгоогүй байгаа 318.6 сая төгрөгийг нэмбэл өмнөх оноос 920.6 сая төгрөгөөр тэтгэвэр тэтгэмж өссөн дүнтэй байна. Өр авлага жил бүр энэ байдлаар нэмэгдвэл орон нутгийн төсөвт багагүй хэмжээний ачаалал үүсэх эрсдэлтэй байна.
- Аймгийн төсвийн нийт зарлагын 30 орчим хувийг халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмж эзэлж байна.

Сумдын их хэмжээний өглөгтэй байгууллагууд:

Иххэт сумын ЗДТГазар 17.2 сая төгрөг, Өргөн сумын ЗДТГазар 17.1 сая төгрөгийн өртэй байна. Өргөн сумын ЗДТГазар 2015 онд үүссэн татвар, НДШ-ийн өр 28.4 сая төгрөгөөс 11.9 сая төгрөгийг барагдуулаагүй байна.

Мөн сумдын орон нутгийн хөгжлийн сан нийт 168.5 сая төгрөгийн өглөгтэй байна.

9.2. Урт хугацаат өр төлбөр:

Урт хугацаат өр төлбөрийн 99.4 хувь буюу 1,841.4 сая төгрөг нь Монгол Улсын Засгийн газар, АХБ-ны хооронд байгуулсан орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжүүлэх төслийн хүрээнд Чандмань-Илч ОНӨХХК-д дамжуулан зээлдүүлсэн зээлийн өглөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн 0.6 хувийг Дагшин-Эрдэнэ ОНӨҮГ-ын 9.7 сая төгрөгийн өглөг эзэлж байна. Өглөг өмнөх оноос 2.0 сая төгрөгөөр буурсан байна.

Арав. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

10.1. Төсвийн төлөвлөгөө:

Аймгийн ИТХ-аас орон нутгийн төсвийг 2016 оны 9, 12 дугаар сард хоёр удаа тодотгон суурь орлогыг 19,159.1 сая төгрөг, суурь зарлагыг 18.367.1 сая төгрөгөөр тооцож 1,234.2 сая төгрөгийн үндсэн тэнцлийн ашигтай байхаар баталсан. Үндсэн тэнцлийн ашиг 1,234.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна.

Сумдын ИТХурал аймгийн хянасан орлогын дүнг хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд 1,246.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Үүнд:

- Замын-Үүд сум 906.4 сая төгрөгөөр, Сайншанд сум 168.4 сая төгрөгөөр, Эрдэнэ сум 56.4 сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэн баталсан.
- Замын-Үүд сум улсын тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн орлогыг, Сайншанд сум улсын тэмдэгтийн хураамж, шууд бус орлогыг, Эрдэнэ сум ан агнуурын хураамжийн орлогыг нэмэгдүүлсэн байна.
- Айраг, Иххэт, Мандах сумын ИТХ аймгийн хянасан орлогын дүнг нэмэгдүүлээгүй.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь улсын төсвөөс санхүүждэг. Гэтэл сумдын ИТХурал тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагыг нэмэгдүүлэн батлах зөрчил гаргаж байна. Тухайлбал: Айраг сумын ЭМТ, Замын-Үүд сумын 4-р цэцэрлэг, Сайншанд сумын 12 дугаар цэцэрлэгийн төсвийг сумын ИТХ-аар нэмэгдүүлснийг аймгийн СТСХэлтэс хяналт тавьж төсвийн нэгдсэн системд оруулаагүй байна.

Мөн Дэлгэрэх сум орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг аймгийн хянасан дүнгээс 430.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд **орон нутгийн нөөц хөрөнгө 442.2 сая төгрөг**, хөрөнгө оруулалт 1,888.3 сая төгрөг, замын сан, мал эмнэлгийн үйлчилгээ, тэтгэмжийн зардалд 540.6 сая төгрөг нийт 2,870.9 сая төгрөгийн зардал баталсан байна. Гэтэл Аймгийн Засаг даргын тамгын газрын төсөвт мөн 400.0 сая төгрөгийн орон нутгийн нөөц хөрөнгийн зардал баталж аймгийн Засаг даргын захирамжаар зарцуулсан байна.

Аймгийн Засаг дарга орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг давхар батлуулан зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Зарим төсвийн орлогыг үндэслэлгүй төлөвлөж байна. Тухайлбал:

- Аймгийн төсвийг батлахдаа газрын дуудлага худалдааны орлогыг үндэслэлгүй нэмэгдүүлэн баталснаас тус орлогын төлөвлөгөө 1,279.7 сая төгрөгөөр биелээгүй. Орлого биелэгдэхгүй байгаад дүгнэлт хийж эрсдлийг тооцоогүйгээс тус орлого сүүлийн 2 жил дараалан биелээгүй байна.
- Замын-Үүд сум хүү, торгуулийн орлогыг үндэслэлгүйгээр 1,038.5 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс тус орлогын төлөвлөгөө тасарч 15 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.
- Сайхандулаан сум өмнөх онд 23 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байсан шууд бус орлогыг хэтэрхий бага дүнгээр буюу 1.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 11.9 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 793 хувиар давж биелсэн.
- Мандах сум ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх барилгын ажлыг тооцоогүйгээс төлөвлөгөөгүй түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 0.2 сая төгрөг орсон.
- Аймгийн ИТХ-аас ус ашигласны төлбөрийг 299.4 сая төгрөгөөр анх баталсан бөгөөд орлого биелэх боломжгүй болсон тул тодотголоор 200 сая төгрөгөөр бууруулж 99.4 сая төгрөг болгон баталжээ. Ус ашигласны төлбөрийн өмнөх оны гүйцэтгэл 155 сая төгрөг байгаа бөгөөд мэргэжлийн байгууллагын тооцоо судалгаагүйгээр өмнөх оны гүйцэтгэлийг 2 дахин нэмэгдүүлж төлөвлөснөөс орлогыг тодотгох нөхцөл үүссэн байна.

10.2. Төсвийн гүйцэтгэл

Аймгийн төсвийн нийт зарлагыг 54.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 50.6 тэрбум төгрөгийн зарлага гарч 3.5 тэрбум төгрөг хэмнэгджээ.

Нийт зардлын гүйцэтгэл /сая төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт+, хэмнэлт-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	54,172.9	50,676.1	-3,496.8
1. Бараа үйлчилгээний зардал	37,397.7	36,134.2	-1,263.5
2. Татаас	397.2	397.2	0
3. Урсгал шилжүүлэг	8,096.9	6,766.7	-1,330.2
4. Хөрөнгийн зардал	8,281.1	7,378.0	-903.1

Төсвийн зарлага нийт дүнгээр хэмнэгдэхэд бараа үйлчилгээний зардал 1.2 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлэг 1.3 тэрбум, хөрөнгийн зардал 0.9 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Бараа үйлчилгээний зардал нийт дүнгээр 1.2 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн боловч дотроо үндсэн цалингийн зардал 227.3 сая төгрөгөөр хэтэрсэн. Үүний шалтгаан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд зардлын хэмнэлтийг аймгийн Татварын хэлтэст шилжүүлж авлагаар тусган зардлыг өсгөснөөс болсон.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлийг сумдаар харуулбал:

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт+, хэмнэлт-	Эзлэх хувь
Дорноговь шууд	16,030.5	13,728.1	(2,302.4)	65.8
Айраг	2,257.9	2,127.9	(130.0)	3.7
Алтанширээ	1,286.7	1,234.2	(52.5)	1.5
Даланжаргалан	1,713.7	1,566.4	(147.3)	4.2
Дэлгэрэх	1,301.3	1,306.5	5.2	-0.1
Иххэт	1,869.8	1,849.1	(20.7)	0.6
Өргөн	1,443.2	1,452.9	9.7	-0.3
Сайхандулаан	1,124.3	1,121.0	(3.3)	0.1
Улаанбадрах	1,434.8	1,238.3	(196.5)	5.6
Хөвсгөл	1,421.7	1,403.6	(18.1)	0.5
Эрдэнэ	1,668.5	1,612.6	(55.9)	1.6
Сайншанд	12,370.4	11,891.8	(478.6)	13.7
Замын-Үүд	7,207.1	7,137.5	(69.6)	2.0
Мандах	1,343.8	1,315.7	(28.1)	0.8
Хатанбулаг	1,699.2	1,690.5	(8.7)	0.2
нийт дүн	54,172.9	50,676.1	(3,496.8)	100.0

Нийт хэмнэлтийн 66 хувийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний буюу 2.3 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт эзэлж байна. Хэмнэлтийн шалтгаан нь:

- ✓ Төсвийн тодотголоор орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын дутуу санхүүжилт 903.2 сая төгрөг дараа онд шилжсэн
- ✓ Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын байгаль хамгаалах зардлын 115.6 сая төгрөгийн ажил хийгдээгүй, захирамжууд цуцлагдсан
- ✓ Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг 1,234.2 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгасан боловч гүйцэтгэлээр шилжүүлээгүй тул хэмнэгдсэн зардлаар харагдаж байна.

Дэлгэрэх сум нийт батлагдсан төсвийг 5.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь ОНХС-гийн төлөвлөгөөг 8.4 сая төгрөгөөр хэтрүүлэн эхний үлдэгдлээс санхүүжүүлснээс шалтгаалсан.

Өргөн сум батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь сумын ЗДТГ-ын батлагдсан төсөв 9.7 сая төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой байна.

Сайншанд сумын төсөв 478.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байгаа нь сум хөгжүүлэх сан 333.2 сая төгрөгийн төлөвлөсөн зээлийг олгоогүй, байгаль хамгаалах сан 40.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 45.0 сая төгрөгийн гүйцэтгэл дутуу байгаагаас шалтгаалсан байна.

Нийт сумдын төлөвлөгөөнд Сум хөгжүүлэх сан, Нөхөн сэргээлтийн сангийн төлөвлөгөөг тусгах болсон, эдгээр сангууд батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргадаггүй нь сумын дүнгээр зардал хэмнэгдэхэд нөлөөлсөн байна.

2015 оны жилийн эцэст орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжилт оройтож ирснээр аймаг, сумын ОНХС-гууд санхүүжилтээ өгч амжаагүй бөгөөд үүнийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүйгээс дараа оны гүйцэтгэл хэтэрсэн харагдаж байна.

ОНХСангийн төлөвлөгөөний хэтрэлт /сая төгрөг/

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт+	Тайлбар
Даланжаргалан	171.3	181.9	10.6	Эхний үлдэгдлээс санхүүжүүлсэн, Дэлгэрэх сум эхний үлдэгдлээс 8 сая төгрөг олгосон ба нэмж 0,4 сая төгрөг олгосон.
Дэлгэрэх	174.5	182.9	8.4	
Өргөн	173.3	176.1	2.8	
Эрдэнэ	238.2	238.8	0.6	
Замын-Үүд	314.7	331.8	17.1	
Дорноговь шууд	2,630.6	2,660.7	30.1	
нийт дүн	3,702.6	3,772.2	69.6	

Арван нэг. Орон нутгийн төсвийн орлого

11.1 Татварын орлого:

Аймгийн ИТХ-аас татварын орлогын төлөвлөгөөг 15,392.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 15,963.6 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Татварын орлогын төлөвлөгөө 571.1 сая төгрөгөөр буюу 103.7 хувиар биелсэн байна.

Биелээгүй 288.3 сая төгрөгийн 6 төрлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Төлөвлөгөө биелээгүй орлогууд /сая төг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дутуу
1	АТБӨЯХАТ	600.1	530.1	70.0
2	Бууны албан татвар	33.8	30.9	2.9
3	Газрын төлбөр	480	387.1	92.9
4	Ус ашигласны төлбөр	99.5	75.6	23.9
5	ТТАМНАТөлбөр	211.8	149.5	62.3
6	Хог хаягдлын хураамж	312.1	275.8	36.3
	нийт дүн	1,737.3	1,449.0	288.3

Орлогын төлөвлөгөө биелээгүй шалтгаан:

- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар:

Нийт 69.9 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө биелээгүй. Татварын хэлтэст албан бичгээр хандсан боловч аудитын явцад тайлбар ирүүлээгүй.

- Бууны албан татвар:

Иргэд бууны шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийлгэдэггүй, тайлант онд хуулинд өөрчлөлт орж бууны албан татвар нэмэгдэж татварын хувь хэмжээ өндөр болсон зэргээс шалтгаалан орлого 2.9 сая төгрөгөөр тасарсан.

- Газрын төлбөр:

Газрын тухай хуулийн дагуу 77 газар эзэмшигч, ашиглагчийн эрхийг цуцалсан, уул уурхайн компаниуд 23.4 сая төгрөгийн төлбөр дутуу, иргэд ААНБ 62.3 сая төгрөгийн төлбөр төлөөгүй байгаа зэрэг нь нөлөөлсөн.

- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр:

Нийт 23.9 сая төгрөгөөр орлого биелээгүй.

Аймгийн хэмжээнд ус ашиглах дүгнэлт бүхий 33 байгууллага байгаагийн 18 байгууллага 53.4 сая төгрөгийн, татварын хяналт шалгалтаар ус ашиглах дүгнэлтгүй 5 байгууллага 18.5 сая төгрөгийн төлбөр төлсөн.

Төлбөр төлөөгүй 15 байгууллагаас хоёр байгууллага үйл ажиллагаа явуулаагүй, нэг байгууллага дараа онд төлсөн, бусад нь тодорхойгүй шалтгаанаар төлөөгүй байна.

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр:

Замын-Үүд суманд баригдах ложистикийн төвтэй холбоотойгоор Эрдэнэ сумын төсөвт 130.2 сая төгрөгийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр орно гэж тооцсон. Гэвч ложистикийн төв барих ажил төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй тул гүйцэтгэлээр 53.0 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөө 77.2 сая төгрөгөөр тасарсан.

- Хог хаягдлын хураамжийн орлого:

Сайншанд сумын орлогыг төлөвлөхдөө 34.9 сая төгрөгийн хог хаягдлын хураамжийг орлогын эх үүсвэр тодорхойгүй байдлаар төлөвлөсөн.

Аймгийн Татварын хэлтсийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар гаргасан тайлбар нь бодит байдалтай нийцээгүй, тооцоо судалгаагүй хандсан байна. Тухайлбал давсан орлогын талаар дүн шинжилгээ хийдэггүй зөвхөн биелээгүй орлогын талаар тайлбар гаргадаг, хог хаягдлын хураамж тасарсан нь Замын-Үүд сумаас шалтгаалсан, усны төлбөрийн орлого уул уурхайн компаниуд жигд ажиллаагүйгээс болсон гэсэн тайлбарууд нь бодит байдалтай нийцэхгүй байна.

Татварын орлогын төлөвлөгөөг Эрдэнэ сум 64.7 хувиар, Мандах сум 96.1 хувиар, Хатанбулаг сум 99.5 хувиар биелүүлж, бусад сумд төлөвлөгөөг 102-135 хувиар давуулан биелүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөө давж биелсэн шалтгаан:

- Алтанширээ, Дэлгэрэх, Мандах сумын хог хаягдлын хураамж 5.2 сая төгрөгөөр давж биелсэн. Алтанширээ сум өвлийн улиралд сумын төв дээр шилжин суурьшсан айл өрхүүдээс хураамж авснаас, Дэлгэрэх сум Засаг чандмань майнз ХХК-иас орж ирэх хураамжийг төлөвлөөгүй байсан зэргээс орлого давсан байна.
- Мандах, Сайншанд, Замын-Үүд сумын түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 15.2 сая төгрөгөөр давж биелсэн. Үүнд Мандах сум тус орлогыг төлөвлөөгүй байсан бөгөөд ОНХС-гийн барилгын ажлаас төлбөрийг суутган төсөвт оруулсан.

- 11 сумын татварын шууд бус орлого 186.8 сая төгрөгөөр давсан. Энэ нь бараа материалын 10 хувийг суутган шилжүүлэх үйл ажиллагаатай холбогдон давж биелсэн. Сайхандулаан сум шууд бус орлогыг 1.5 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 11.9 сая төгрөгийн орлого орсон.
- 5 сумын улсын тэмдэгтийн хураамж 363.9 сая төгрөгөөр, үүнээс Замын-Үүд сумын у/т/хураамж 356.1 сая төгрөгөөр давж биелсэн. ГИХГ-аас Төсвийн тухай хуулийн 23.4.9-т заасан улсын тэмдэгтийн хураамжийг Замын-Үүд сумын орлогод төвлөрүүлснээр уг орлогын төлөвлөгөө давж биелсэн.

11.2. Татварын бус орлого

Аймгийн ИТХ-аас татварын бус орлогыг 2,035.3 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 730.9 сая төгрөг төвлөрч, орлого 1,304.4 сая төгрөгөөр тасарчээ.

Татварын бус орлого тасарсан шалтгаан нь:

- Замын-Үүд сум аймгийн ИТХ-ын хянасан төсвийг 906.4 сая төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталсан. Үүнд хүү торгуулийн орлогыг 1,388.5 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 208.5 сая төгрөг төвлөрч, уг орлого 1,185.3 сая төгрөгөөр тасарсан.
- Жилийн эцэст Эрдэнэ сумын төсвийн орлого биелэхгүй нөхцөл байдал үүссэн тул сумын түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг бууруулж, бууруулсан хэмжээгээр аймгийн төсвийн нэр зааж ангилагдаагүй орлогыг 198.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь татварын бус орлогын төлөвлөгөө биелэхгүй байхад мөн нөлөөлсөн байна.

11.3. Хөрөнгийн орлого

Газрын дуудлага худалдааны орлогыг 1,660.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 381.2 сая төгрөгийн орлого орж, төлөвлөгөө 1,279.7 сая төгрөгөөр биелээгүй.

Орлогын төлөвлөгөө 77 хувиар тасарч биелээгүй нь аймгийн ИТХ-аас уг орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, сумдад зохион байгуулсан дуудлага худалдааны 72 хувь нь оролцогч ирээгүй, бүрдээгүй шалтгаанаар хүчингүй болсон зэргээс шалтгаалсан байна.

Өмнөх онд мөн аймгийн ИТХ газрын дуудлага худалдааны орлогыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн шалтгаанаар төлөвлөгөө 623.7 сая төгрөгөөр тасарч байсан.

Арван хоёр. Орон нутгийн төсвийн зарлага

12.1. Урсгал зардал

Тайлант онд урсгал зардалд нийт 45,891.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 43,298.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсөв (2,593.7) сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Урсгал зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулбал:

			/сая төг/
ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт+ хэмнэлт-
Урсгал зардал:	45,891.7	43,298.0	-2,593.7
1.Бараа үйлчилгээний зардал	37,397.6	36,134.1	-1,263.5
1.1. Цалин хөлс	21,065.9	21,071.2	5.3
1.2. НДШ	2,389.9	2,353.1	-36.8
1.3. Бараа үйлчилгээний бусад зардал	13,941.8	12,709.8	-1,232.0
3.Татаас ба урсгал шилжүүлэг	8,494.1	7,163.9	-1,330.2

Цалин хөлсний зардал 5.3 сая төгрөгөөр хэтэрч, НДШ болон бараа үйлчилгээний бусад зардал 1,268.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

12.2. Хөрөнгийн зардал

Хөрөнгийн зардал нийт 8,281.1 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэл 89.1 хувьтай буюу 903.1 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Орон нутгийн хөгжлийн сан	5,579.9	5,556.4	23.5
2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1,888.3	1,318.7	569.6
3	Замын сан	235.0	0	235.0
4	Замын-Үүд сумын хөрөнгө оруулалт	577.9	502.8	75.1
	Нийт дүн	8,281.1	7377.9	903.1

УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолоор “төсвийн хөрөнгөөр шинээр автомашин худлдан авахгүй байх”-ыг Засгийн газарт даалгасан. УИХ-ын тогтоолыг зөрчин 2 байгууллага автомашин худалдан авсан байна. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг сумын ЗДТГазарт 35.0 сая төгрөгийн үнэтэй жийп автомашин худалдан авсан.
- Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар Гадаадын иргэн харьяатын газарт 129.0 сая төгрөгөөр ниссан патрол Y-62 маркийн жийп автомашин, мөн 34.1 сая төгрөгөөр старекс маркийн автомашин худалдан авах зориулалтаар эрх шилжүүлэн санхүүжүүлсэн.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалт нь хууль журам зөрчиж байна. Тухайлбал:

- Сумын ЗДТГ-ын урсгал зардлын дансаар дамжуулан сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын ажилд 502.8 сая төгрөгийг зарцуулсан.
- Төсвийн шууд захирагчийн данснаас сумын хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлсэн, хөрөнгө оруулалтыг Орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулж хийгээгүй зэрэг нь Төсвийн тухай хууль болон бусад холбогдох заавар журамд нийцэхгүй байна.
- Замын-Үүд сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 314.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй. Шалтгаан нь сумын ЗДТГ-аас

хөрөнгийн тоо ширхэг, нэг бүрийн үнэ зэргийг хөрөнгийг хүлээн авч буй байгууллагад дэлгэрэнгүй байдлаар гаргаж өгөөгүй байна.

Аудитын газраас ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтын 2016 оны гүйцэтгэлд нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийж тайланг тусад нь тайлагнасан тул энд дурдаагүй болно.

Арван гурав. Төсөл, сангийн бүртгэл, тайлагнал

Аймгийн ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах сангууд нэгтгэгдсэн байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сан
- ✓ Сум хөгжүүлэх сан
- ✓ Нөхөн сэргээлтийн сан
- ✓ Байгаль хамгаалах сан
- ✓ Мал хамгаалах сан

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс хууль журамд нийцүүлэн сумдын мал хамгаалах сан, байгаль хамгаалах сангийн дансыг хааж, зарцуулалтыг зогсоосон байна.

Сангуудын ажил гүйлгээнд нягтлан бодох бүртгэл хөтөлдөггүй, дансны хуулгын орлого, зарлагыг үндэслэн санхүүгийн тайлан гаргаж ирсэн байна.

- Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөггүй, хариуцсан нягтлан бодогч тодорхойгүй зэргээс шалтгаалж, зээлийн авлага, орлого, үр дүн буруу тайлагнагдаж байна.
- Ажил гүйлгээг журналд бичээгүй, дэлгэрэнгүй болон болон ерөнхий данс хөтлөхгүйгээр санхүүгийн тайлан гаргаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг зөрчиж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасны дагуу уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нар байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэх баталгаа болгон тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг Нөхөн сэргээлтийн сан дансанд шилжүүлдэг байна.

Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Улаанбадрах сум нөхөн сэргээлтийн сангаас нийт 175.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 39.0 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс Улаанбадрах сум Кожеговь ХХК-д барьцаа хөрөнгө 37.4 сая төгрөгийг буцаан олгож, үлдсэн сумд 1.6 сая төгрөгийг ажлын хөлс болон бусад зардалд зарцуулсан байна.

Тусгай дансны мөнгийг бусад зориулалтаар зарцуулж байгаа нь: Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 тушаалаар батлагдсан журмын 3.2-т “тусгай дансанд байршуулсан хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгоно”, 5.5-д “энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна.

Арван дөрөв. Орон нутгийн өмчит компаниуд

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь 9.7 тэрбум төгрөгийн борлуулалтын цэвэр орлоготой, 10.4 тэрбум төгрөгийн зарлагатай ажилласан байна.

Орон нутгийн өмчит компаниудын үр дүн /сая төг/

№	Байгууллагын нэр	Орлого	Зарлага	Үр дүн
1	Чандмань-Илч	5,432.8	5,962.1	-529.3
2	Чандмань-Бадрал	2,237.1	2,109.4	127.7
3	Замын-Үүд НААҮ	512.0	598.0	-86.0
4	Эм эргэлтийн сан	1,053.7	1,075.3	-21.6
5	Дагшин-Эрдэнэ	66.9	150.5	-83.6
6	Нийтлэг үйлчилгээний газар	440.5	479.6	-39.1
Нийт дүн		9,743.0	10,374.9	-631.9


Тайлант онд Чандмань-Бадрал ОНӨҮГ 127.7 сая төгрөгийн ашигтай, бусад нь 21.6 – 529.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. /хүснэгт/

Аудитаар Чандмань-Илч ОНӨХХК, Эм эргэлтийн сан ОНӨҮГ-ийн санхүүгийн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт, бусад байгууллагад зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Чандмань-Илч ОНӨХХК 436.9 сая төгрөгийн авлага, Эм эргэлтийн сан ОНӨҮГ 15.4 сая төгрөгийн өр авлага, 647.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй байсан тул хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Арван тав. Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн

Аймгийн Аудитын газраас 2017 оны 1-р улиралд орон нутгийн төсвийн 23, орон нутгийн өмчит 6, тусгай зориулалтын шилжүүлгийн 38 байгууллага нийт 67 байгууллагын санхүүгийн тайланд аудитад хийлээ. Эдгээрээс 57 байгууллагад зөрчилгүй, 9 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад татгалзсан дүгнэлт өгсөн. Зөрчилтэй дүгнэлт авсан байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох тухай албан бичгийг хүргүүлсэн.



Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2016 оны санхүүгийн тайланд татгалзсан санал дүгнэлт өгсөн.

Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагуудыг харуулбал:

- Дэлгэрэх, Замын-Үүд сумын ЗДТГ
- Чандмань-Илч ОНӨХХК, Эм эргэлтийн сан ОНӨҮГ
- Айраг, Дэлгэрэх сумын ЕБС, Замын-Үүд сумын 2-р сургууль, Сайншанд сумын 5-р сургууль
- Сайншанд сумын 5-р багийн хүүхдийн цэцэрлэг

Мөн сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн бөгөөд Хатанбулаг, Замын-Үүд сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, бусад сумын нэгтгэсэн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Аудитын олон улсын стандарт, ҮАГ-аас гаргасан заавар журмын дагуу 50 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Санхүүгийн тайланд итгэл үзүүлэх журам”-ын дагуу 15 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүллээ.

Төсвийн шууд захирагчдын тайланд 4,572.1 сая төгрөгийн, орон нутгийн өмчит компаниудын тайланд 1,348.1 сая төгрөгийн, төвлөрүүлэн захирагчдын тайланд 4,732.1 сая төгрөгийн нийт 10,652.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,109.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залрууллаа. Аудитаар 54.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 18.2 сая төгрөгийн төлбөрийн акт, бусад зөрчилд нийт 206 зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилтэй дүгнэлт авсан байгууллагын жагсаалтыг хавсралт 1-ээр, нийт төсөвт байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ТЕЗ-ийн өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

№	Зөвлөмжийн товч утга	Биелэлт
1	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүй арилжааны банкинд нээсэн Шинэ Дорноговь сан, Газар тариалан эрхлэлт ойжуулалтыг дэмжих сан, аймгийн Эрчим хүчний зөвлөл, Малчдад туслах хандивын данс зэрэг 5 дансыг хаах	Арилжааны банкин дахь зөвшөөрөлгүй дансыг хааж үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн. Данс хаасан тухай албан бичгийн хуулбарыг ирүүлсэн.
2	Орон нутгийн төсвийн шууд захирагчдийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилган аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллахад анхаарах	Зөрчилтэй дүгнэлт авсан 10 байгууллагын харьяалах сумын Засаг дарга нарт зөрчил гаргасан албан тушаалтнуудад арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон.
3	Орон нутгийн ТЕЗ-ийн болон төсвийн шууд захирагчдын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах	Бодлогын баримт бичиг боловсруулахыг бүх шатны нягтлан бодогч нарт даалгасан боловч хэрэгжүүлээгүй. Иймд СТСХэлтсээс жишиг бодлогын баримт бичиг гаргаж сумдад мөрдүүлэх талаар судалж хэрэгжүүлэх шатандаа явж байна.

ТАЙЛАНТ ОНЫ АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчид:

1. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкинд байршуулсан 60.0 сая төгрөг, 2000 онд улсын төсвөөс авч сумдад дамжуулан зээлдүүлсэн өвс тэжээлийн авлага 23.2 сая төгрөг, хандивын сан нэртэй дансны эзэн холбогдогч тодорхойгүй 21.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ авах
2. Халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ өнгөрсөн онд 920.6 сая төгрөгөөр өссөн бөгөөд өр авлага жил бүр энэ байдлаар нэмэгдвэл орон нутгийн төсөвт ачаалал үүсэх эрсдэлтэй. Иймд одоо үүсээд байгаа өр авлагыг нягтлах, өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй байхад олгосон 343.7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийн анхан шатны баримтыг шалгаж баталгаажуулах
3. Газрын дуудлага худалдааны орлого, Замын-Үүд сумын хүү торгуулийн орлогыг 2 жил дараалан үндэслэлгүй нэмэгдүүлж төлөвлөсөн нь аймгийн төсвийн орлого тасрахад голлон нөлөөлсөн байгаа тул төсвийн орлогыг үндэслэлтэй зөв төлөвлөхөд анхаарал хандуулах
4. Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг давхар батлуулан зарцуулж байгаа зөрчлийг арилгах

Санхүү төрийн сангийн хэлтсийн даргад:

